

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/140-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг:
enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг:
batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК

Утас: 99102291 Цахим хаяг: Nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № 107-2022/140-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

МАНДАЛ СУМЫН 6 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т. ЛХАГВАЖАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа:2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,828,525.15	16,724,998.27
33	АВЛАГА		
331	Ажиллагсадтай холбогдсон авлага		41,831.12
35	БАРАА МАТЕРИАЛ	18,828,525.15	16,683,167.15
354	Хангамжийн материал	18,828,525.15	16,683,167.15
3542	Аж ахуйн материал	10,594,653.5	11,413,345.5
3544	Түлш, шатах тослох материал	12,000	12,000
3546	Хүнсний материал	5,009,570.25	295,520.25
3547	Бусад хангамжийн материал	3,212,301.4	4,962,301.4
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,185,400,514.92	1,159,464,245.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,185,400,514.92	1,159,464,245.18
392	Биет хөрөнгө	1,168,275,514.9	1,142,589,245.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,130,074,193	1,130,074,193
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55,940,695.48	-72,075,568.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	75,116,785	77,616,785
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,378,166.62	-31,077,350.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,612,586	54,612,586
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,277,312.36	-32,067,025.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,339,592	14,339,592
39215	Хуримтлагдсан элэгдэл	-504,166.64	-1,066,666.64
39217	Ном	2,232,700	2,232,700
393	Биет бус хөрөнгө	17,125,000.02	16,875,000.06
39301	Программ хангамж	1,250,000	1,250,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-124,999.98	-374,999.94
39303	Бусад биет бус хөрөнгө	16,000,000	16,000,000
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,204,229,040.07	1,176,189,243.45
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,204,229,040.07	1,176,147,412.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1,204,229,040.07	1,176,147,412.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	97,199,969.64	97,199,969.64
512	Хуримтлагдсан үр дүн	1,091,808,917.64	1,063,727,289.9

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5121	Өмнөх үеийн үр дүн	1,010,556,821.9	1,091,808,917.64
5122	Тайлант үеийн үр дүн	81,252,095.74	-28,039,796.62
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,220,152.79	15,220,152.79
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,204,229,040.07	1,176,189,243.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	573,325,455.00	460,815,091.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,439,055.00	3,438,092.00
120	Нийтлэг татварын бус орлого	84,439,055.00	3,438,092.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	84,305,615.00	1,000,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	133,440.00	2,438,092.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,886,400.00	457,376,999.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	447,576,700.00	421,038,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	447,576,700.00	421,038,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		235,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн		235,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,309,700.00	36,103,399.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,309,700.00	36,103,399.36
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	492,073,359.26	488,854,887.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,073,359.26	488,854,887.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,644,723.91	468,545,204.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,957,712.63	332,125,843.71
210101	Үндсэн цалин	299,203,885.62	193,879,330.70
210102	Нэмэгдэл	16,696,158.51	113,036,754.43
210104	Урамшуулал	19,057,668.50	25,209,758.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,448,482.02	43,605,91.98
210201	Тэтгэврийн даатгал	29,082,620.05	30,234,728.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,848,050.27	3,342,765.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,166,584.98	2,674,212.36

210204	Ажилгүйдлийн даатгал	668,289.34	668,553.41
21205	Эрүүл мэндийн даатгал	6,682,937.38	6,685,531.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,480,500.00	35,580,499.36
210301	Гэрэл, цахилгаан	2,820,973.20	3,314,901.36
210302	Түлш, халаалт	33,132,312.80	31,608,352.00
210303	Цэвэр, бохир ус	4,527,214.00	657,246.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,746,300.00	3,306,300.00
210401	Бичиг хэрэг	633,000.00	547,300.00
210402	Тээвэр, шатахуун	415,800.00	323,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	590,000.00	847,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	919,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		669,400.00
2105	Нормативт зардал	20,895,290.00	13,938,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,700.00	77,700.00
210502	Хоол, хүнс	20,810,590.00	13,860,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,497,750.00	1,665,800.00
210604	Урсгал засвар	4,497,750.00	1,665,800.00
2107	Томилолт, зочны зардал	135,600.00	120,000.00
210702	Дотоод албан томилолт	135,600.00	120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,000.00	6,861,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,000.00	6,375,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	486,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,679,089.26	31,340,669.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	702,340.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,451,000.00	1,904,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,525,749.26	29,436,269.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,428,635.35	20,309,683.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,428,635.35	20,309,683.19
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,428,635.35	20,309,683.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	81,252,095.74	-28,039,796.62
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	81,252,095.74	-28,039,796.62

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,010,556,821.90	1,122,976,944.33
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,010,556,821.90	1,122,976,944.33
Тайлант үеийн үр дүн			81,252,095.74	81,252,095.74
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,091,808,917.64	1,204,229,040.07
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,091,808,917.64	1,204,229,040.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,091,808,917.64	1,204,229,040.07
Тайлант үеийн үр дүн			-28,039,796.62	-28,039,796.62
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	97,199,969.64	15,220,152.79	1,063,769,121.02	1,176,189,243.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	488,886,400.00	457,376,999.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,886,400.00	457,376,999.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	447,576,700.00	421,038,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	447,576,700.00	421,038,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		235,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		235,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,309,700.00	36,103,399.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,309,700.00	36,103,399.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,918,000.00	454,876,999.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,918,000.00	454,876,999.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,489,364.65	434,567,316.17

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,957,712.63	332,125,843.71
210101	Үндсэн цалин	299,203,885.62	193,879,330.7
210102	Нэмэгдэл	16,696,158.51	113,036,754.43
210104	Урамшуулал	19,057,668.50	25,209,758.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,448,482.02	43,647,623.10
210201	Тэтгэврийн даатгал	29,082,620.05	30,276,560.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,848,050.27	3,342,765.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,166,584.98	2,674,212.36
210204	Ажилгүйдлийн даатгал	668,289.34	668,553.41
210205	Эрүүл мэндийн даатгал	6,682,937.38	6,685,531.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,480,500.00	35,580,499.36
210301	Гэрэл, цахилгаан	2,820,973.20	3,314,901.36
210302	Түлш, халаалт	33,132,312.80	31,608,352.00
210303	Цэвэр, бохир ус	4,527,214.00	657,246.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,141,600.00	2,636,900.00
210401	Бичиг хэрэг	132,700.00	547,30.000
210402	Тээвэр, шатахуун	415,800.00	323,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	107,500.00	
210404	Ном, хэвлэл	96,600.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,150,000.00	847,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,239,000.00	919,100.00
2105	Нормативт зардал	27,622,520.00	10,024,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,700.00	77,700.00
210502	Хоол, хүнс	24,422,820.00	9,146,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,115,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,354,750.00	1,665,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,881,000.00	
210604	Урсгал засвар	4,473,750.00	1,665,800.00
2107	Томилолт, зочны зардал	135,600.00	120,000.00
210702	Дотоод албан томилолт	135,600.00	120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,000.00	6,861,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,000.00	6,375,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	486,000.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,544,200.00	1,904,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	592,900.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,951,300.00	1,904,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,428,635.35	20,309,683.19
2133	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,428,635.35	20,309,683.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,428,635.35	20,309,683.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,968,400.00	2,500,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,968,400.00	2,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,968,400.00	2,500,000.00
	Дотоод эх үүсвэрээр	12,968,400.00	2,500,000.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,968,400.00	2,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-12,968,400.00	-2,500,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр//

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	457,142,000.00	436,832,316.17	20,309,683.83	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	457,142,000.00	436,832,316.17	20,309,683.83	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	457,142,000.00	436,832,316.17	20,309,683.83	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,296,400.00	332,125,843.71	6,170,556.29	98.1
210101	Үндсэн цалин	244,188,700.00	193,879,330.70	50,309,369.30	79.4
210102	Нэмэгдэл	70,481,500.00	113,036,754.43	(42,555,254.43)	160.3
210104	Урамшуулал	23,626,200.00	25,209,758.58	(1,583,558.58)	106.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,206,300.00	43,647,623.10	558,676.90	98.7
210201	Тэтгэврийн даатгал	30,674,400.00	30,276,560.03	397,839.97	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,383,000.00	3,342,765.91	40,234.09	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,706,400.00	2,674,212.36	32,187.64	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	676,600.00	668,553.41	8,046.59	98.8

210205	Эрүүл мэндийн даатгал	6,765,900.00	6,685,531.39	80,368.61	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,580,500.00	35,580,499.36	0.64	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,291,000.00	3,314,901.36	1,976,098.64	62.6
210302	Түлш, халаалт	29,824,200.00	31,608,352.00	(1,784,152.00)	105.9
210303	Цэвэр, бохир ус	465,300.00	657,246.00	(191,946.00)	141.2
2104	Хангамж, бараа материалын зардал	2,401,900.00	2,401,900.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	121,900.00	547,300.00	(425,400.00)	148.9
210402	Тээвэр, шатахуун	323,400.00	323,400.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	637,700.00		637,700.00	-
210404	Ном, хэвлэл	88,600.00		88,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,900.00	612,100.00	(71,200.00)	113.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	689,400.00	919,100.00	(229,700.00)	133.3
2105	Нормативт зардал	22,668,100.00	10,024,500.00	12,643,600.00	44.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,700.00	77,700.00	-	100.0
210502	Хоол, хүнс	21,772,500.00	9,146,800.00	12,625,700.00	42.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	817,900.00	800,000.00	17,900.00	97.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,165,800.00	4,165,800.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,665,800.00	1,665,800.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	124,600.00	120,000.00	4,600.00	96.3
210702	Дотоод албан томилолт	124,600.00	120,000.00	4,600.00	96.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,794,000.00	6,861,750.00	932,250.00	88.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,498,000.00	6,375,750.00	122,250.00	98.1
2109	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	486,000.00	810,000.00	37.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,400.00	1,904,400.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,904,400.00	1,904,400.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	457,142,000.00	436,832,316.17	20,309,683.83	95.5
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	421,038,600.00	400,728,916.81	20,309,683.19	95.1

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	421,038,600.00	400,728,916.81	20,309,683.19	95.1
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,103,400.00	36,103,399.36	0.64	100.0
132006	Орон нутгийн төсвөөс	36,103,400.00	36,103,399.36	0.64	100.0
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29		
6	Удирдах ажилтан	1	1		
7	Гүйцэтгэх ажилтан	10	10		
8	Үйлчлэх ажилтан	18	18		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	235,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	235,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	235,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн /цаашид Мандал сумын 6 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өгсөн цахим төлбөрийн баримт, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Ч.Ганчулуун гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын 6 дугаар цэцэрлэг нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Боловсролын салбарын хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн албан хаагчийн ес зүй, хариуцлага, дэг журмыг дээдлэн сахиж хүүхэд нэг бүрийн бие даасан байдлыг дэмжсэн таатай орчинд тэдний авьяас чадварыг нээн илрүүлэх шилдэг арга зүйтэй, мэргэшсэн чадварлаг боловсон хүчинтэй, эцэх эх, олон нийтийн итгэл хүндэтгэлийг хүлээсэн хүүхдэд ээлтэй байгуулга болох” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын менежментийг сайжруулж, СӨБ-ын стандартад нийцсэн сургалтын таатай орчин бүрдүүлэх,
- Багш, удирдах ажилтны хөгжлийг дэмжиж, ёсзүйг сахиулж, үр дүнг тооцох,
- “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхэд бүрийг цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгох,
- Цэцэрлэгийн бодлого, төлөвлөлт, үйлчилгээний чанар, үр дүнд, эцэг, эх сурагчдын оролцоог нэмэгдүүлэх,
- Өдрийн дэглэмийн дагуу үйл ажиллагаанд гэнэтийн болон төлөвлөгөөт, хэсэгчилсэн хяналт хийж өдөр тутмын ажлын хариуцлагыг сайжруулах,
- Хүүхдийн дадал хэвшил таних тэмдэгт хяналт тавьж зөрчил дутагдлыг тухай бүр арилгаж ажлыг тогтмолжуулах,
- Хүүхэд бүрийн хөгжлийн үнэлгээнд хяналт тавих,
- Цэцэрлэгийн анги танхим, эрүүл ахуй халдвар хамгаалалтад хяналт тавьж зөвлөн туслах, зөрчил дутагдлыг цаг тухай бүрд арилгах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” журам тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын хийсэн боловч алдаа зөрчил илрээгүй гэж дүгнэжээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 488,896.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,888.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн байдлыг 70 хувиар буюу 3,422.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,039.8 мянган төгрөг буюу 2.3 хувиар буурсан ба өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээний өөрчлөлттэй нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	41.8	41.8
Бараа материал	18,828.5	16,683.2	(2,145.3)
Үндсэн хөрөнгө	1,185,400.5	1,159,464.2	(25,936.3)
Нийт хөрөнгө	1,204,229.0	1,176,189.2	(28,039.8)
Богино хугацаат өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,204,229.0	1,176,189.2	(28,039.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,204,229.0	1,176,189.2	(28,039.8)

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 41.8 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 16,683.2 мянган төгрөг болж, 2,145.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны хүнсний материалын үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,296,125.9 мянган төгрөг / анхны өртгөөр / болж 3,500.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, иргэнээс хандиваар 1,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэл, тайланд тусгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,176,147.4 мянган төгрөг болж 28,081.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 112,510.3 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй болон тусламж, санхүүжилтийн орлого буурсантай холбоотой байна.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 3,176.6 мянган төгрөгөөр буурсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудын бууралтаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 521,875.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг төсвийн төслөөс 64,733.4 мянган төгрөгөөр бууруулж, 457,142.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **457,142.0** мянган төгрөгийн төсөв баталснаас 421,038.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 36,103.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 421,038.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,103.4 мянган төгрөг, нийт 457,142.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 436,832.3 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 20,309.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **436,832.3** мянган төгрөг буюу 95.5 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 6,729.3 мянган төгрөгөөр, нормативт зардал 12,643.6 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 4.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 932.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Мандал сумын ЗДТГ-аас 235.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосныг зориулалтын дагуу хангамж, бараа материалын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл*

ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 457,142.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр 436,832.3 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг 4.5 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасантай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 796.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,341.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	796.0	1	796.0	100
Албан шаардлага	1	2,341.7	1	2,341.7	100
Зөвлөмж	2		1		50
Нийт дүн	4	2,144.2	3	2,144.2	75.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2. Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 59,370.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагад хамааралгүй 2,474.1 мянган төгрөгийн худалдан авалт илүү шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44,151.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 35,459.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 8,692.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 35,459.6 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд Нийгмийн даатгалын шимтгэлийн 41.8 мянган төгрөгийн авлагыг бүртгэж, тайлагналгүй орхигдуулсан;
- Хөрөнгийн тооллогын бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн нэгтгэлийн дүн жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн үлдэгдлээс 35,417.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Төлбөрийн баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 7,892.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

1.1 Илрүүлэлт: Нормын хувцас, зөөлөн эдлэл зардлаас худалдан авсан 800.0 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцсыг бараа материалын бусад материалын дансанд орлого авч тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 4.10, 2.1.4 гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул хөрөнгийн ангилал болон нэршлийг зөв бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сумын 6 дугаар цэцэрлэг	4	44,151.6	2	35,459.6	-	-	-	-	2	8,692.0